# ХЭНТИЙ АЙМГИЙН
# ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 08 өдөр Дугаар А/98 Дэлгэрхаан сум

Гоц халдварт хонины цэцэг өвчнөөс
урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх хэсэг, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын А/264 дүгээр тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын А/483 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээний бүх хонин сүргийг цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 29 хоногийн хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн, захирал малын эмч нарт үүрэг болгосугай.

2.Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хороо бэлтгүүлэх, дархлаажуулалтад ажиллах хүн машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангуулан ажиллахыг 1,2,3,4,5-н багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтын ажлыг зохион байгуулахад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчин, мал бүхий иргэд заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Баярмаа)-д даалгасугай.

4.Дархлаажуулалтад шаардлагатай вакцин,мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Баярмаа)-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч ( Д.Батнасан)-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЭНХ-АМГАЛАН

2325010209

ᠰᠣᠶᠣᠯ ᠰᠣᠨᠢᠰᠬᠤᠯᠠᠩ ᠤᠨ ᠶᠠᠮᠤ ᠳᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠤᠨ ᠬᠡᠯᠡᠲᠡᠰ

2024 ᠣᠨ ᠤ 06 ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 07 ᠡᠳᠦᠷ ᠳᠤᠭᠠᠷ 218

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡ ᠶᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠲᠤᠬᠠᠢ

ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠣᠯᠣᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠨᠠᠷ ᠲᠠ

᠑ :: ...

᠒ :: ...

᠓ :: ...

᠔ :: ...

ᠲᠤᠰ ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠲᠡᠷᠢᠭᠦᠨ ᠰᠠᠢᠳ ...